

# БОЛОВСРОЛ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД НӨЛӨӨЛСӨН НЬ

Б. Сэржав

Япон улс эдийн засгаа сүүлийн 40 гаруй жилд маш түргэн хөгжүүлж, асар их хүч чадлыг эзэмшин, дэлхийн тэргүүний аж үйлдвэржсэн орон боллоо.

Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш эдийн засгийн дундаж өсөлт дайн дууссанаас 50-иад оны эхний хагас хүртэлх сэргэлтийн жилүүдэд 8,5%, 50-иад оны сүүлийн хагасаас 60-аад оны дунд үе хүртэлх жигд өндөр хөгжлийн жилүүдэд 11,8% байсан бөгөөд 70-аад оноос хойш энэ хурдац бага зэрэг буурсан хэдий ч олон улсын хэмжээнд авч үзвэл өндөр байлаа. Япон улс урьд өмнө хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүн голлон үйлдвэрлэж байсан бол энэ хугацаанд тэргүүний технологийн үндсэн дээр голдуу химийн болон хүнд үйлдвэрийн сайн чанарын бүтээгдэхүүн, өргөн хэрэглээний төрөл бүрийн эд бараа үйлдвэрлэдэг боллоо.

Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн хувьд бүр 70-аад онд ган, хөлөг онгоц, автомашин үйлдвэрлэлээр тоо, чанарын аль аль үзүүлэлтээр дэлхийд тэргүүн байрт гарч, сүүлийн жилүүдэд тэргүүний өндөр технологи голлосон аж үйлдвэрийн робот, хагас дамжуулагч, электрон техникийн бараагаар мөн тэргүүн байрт нэгэнт орлоо. Мэдээлэл, үйлчилгээний салбар ч дэлхийн тэргүүний түвшинд хүрчээ. Эдийн засгийн цар хэмжээ, материаллаг үйлдвэрлэлийн тухайд Мэйжи-гийн (1868—1911) шинэчлэлийн үеэс зорьж ирсэн «хөөн гүйцэх, гүйцэж түрүүлэх» мөрөөдөл нэгэнт биеллээ.

---

<sup>1</sup> Б. Сэржав. ШУА-ийн Зүүн хойт Ази судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан

1990 оны үзүүлэлтээр Япон улсын нийгмийн нийт бүтээгдэхүүн 3 триллион 346 сая америк доллар (435 триллион иэн), түүний жилийн дундаж өсөлт 1985—89 онд 5,7% байна. Хойшид нийгэм насжих сөрөг хандлага бий хэдий ч электроник төхөөрөмж голлосон шинэ өндөр технологийн тусламжтайгаар нийгмийн нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлтийг 3—5%-д тогтмол байлгах боломжтой. 2000 он гэхэд энэ үзүүлэлт жилдээ 4% байна гэж Японы эрдэмтэд тооцоолжээ. Түүгээр ч зогсохгүй ирэх ХХI зуунд дэлхийн эдийн засгийн хөгжлийн төв Ази тивд шилжинэ, ирэх зуун Японых болно гэж олон эрдэмтэд үзэж байна.

Япон улсын эдийн засгийн энэ гайхамшигт хөгжилд хүрэхэд нөлөөлсөн хүчин зүйлүүдийг олон эрдэмтэд олон талаас нь тайлбарласан байдаг. Тухайлбал Америкийн эрдэмтэн **Эдвин О. Рейшауэр**

— Хүнд хүчир хөдөлмөрийг давж гарах хүч чадал, боловсролын өндөр түвшин, нарийн технологи, улс төр, санхүүгийн тогтвортой байдлаа хадгалж чадах япончуудын онцгой чанар.

— Аж үйлдвэржихэд хөрөнгө хүчээ зөв төвлөрүүлсэн явдал.

— Сайн чанарын нүүрс, нефтийг алс холоос их хэмжээгээр импортлох боломж нээгдэж эрчим хүчний нөөц боломж өргөжсөн.

— Эдийн засгийн хөгжлийн эхний шатнаас Америк улс бүтээгдэхүүнийг нь чөлөөтэйгээр оруулж, Японы хувьд чухал зах зээл болж өгсөн.

— Дайнд ялагдаж эзэмшил нутгаа алдсан нь тэдгээр эзэмшил нутагт зарцуулах батлан хамгаалалтын болон бусад олон зардлыг зогсоож, тэр хөрөнгийг дотоодын аж үйлдвэр хөгжих чухал түлхэл болгосон.

— Милитаризмын эсрэг олон нийтийн тэмцэл, Америктай удаа дараа байгуулсан аюулгүйн гэрээ зэргийн нөлөөгөөр цэргийн зардлыг доод хэмжээнд барьж байсан.

— Үйлдвэрлэлийг чөлөөтэй хөгжүүлэх систем тогтож, засгийн газрын жолоодлого, зохицуулалтыг зөвөөр хослосон гэх мэт 8 хүчин зүйлсийг дурдаад эдгээрээс хамгийн гол нь эхний хүчин зүйл гэж үзжээ.

Мөн Японы нэрт эдийн засагч **Такахаши Камэкичи** «Дайнаас хойшхи Японы эдийн засгийн үсрэлтийн үндсэн хүчин зүйл» (1975) номдоо эдийн засгийн хөгжлийг гадаад дотоод 2 хүчин зүйлээр тайлбарлажээ. Үүнд гадаад хүчин зүйлд:

— Материал түүхий эдийн нөөц газар өөрчлөгдсөнөөр хүнд химийн үйлдвэрийн түүхий эдийн хомсдол үгүй болж дайны өмнөх үеийнхээс ашигтай нөхцөл бүрдсэн.

— Дайны үед болон дайнаас хойш дэлхийн гол гол улсуудад хийсэн технологийн их үсрэлтийг, дайнд үйлдвэрийн газрууд, тоног төхөөрөмжөө сүйтгүүлсэн Япон улс өөртөө ашигтайгаар ашиглаж чадсан.

— Дайнд ялагдаж эзэмшил газруудаа алдсан зэрэг нь эцсийн эцэст Японы эдийн засгийг хөгжүүлэх хүчин зүйл болж хувирсан гэжээ.

— Мөн дотоод хүчин зүйлд:

— Их хэмжээний ажиллах хүч, ард түмний гайхамшигт иргэнлэг чанар, боловсрол мэдлэг, аж ахуйг эрхлэх уламжлалт арга барил, үйлдвэрлэлийн газрын өвөрмөц зохион байгуулалт, засгийн газар, үйлдвэрийн хамтын ажиллагаа, аж үйлдвэрүүдэд гадаадаас хөрөнгийг оруулсан зэрэг японы өөрийн онцлогтой нийгэм эдийн засгийн системийг бий болгосон зэргийг дурджээ.

Энэ мэтчилэн судлаачдын бүтээлийг харьцуулан үзвэл:

— Сайн боловсорсон сайн мэдлэгтэй сахилга бат зохион байгуулалт сайтай ажиллах хүч.

— Овсгоо самбаатай, санаачлагатай байх асуудал.

— Дотоодын хуримтлалын түвшинг өндөр байлгаж чадсан.

— Улсаас маш зөв бодлого явуулсан

— Гадаад эдийн засгийн аятай нөхцөл байдал бүрдсэн зэрэг хүчин зүйл нь сүүлийн 40 гаруйхан жилийн хугацаанд Японыг дэлхийн тэргүүний орон болгожээ гэсэн дүгнэлтэд хүрсэн байх юм.

Ингэж эдийн засаг, шинжлэх ухаан техникийн асар хурдан хөгжлийг хэрэгжүүлсэн гол эзэн болох боловсролтой хүнийг бэлтгэж чадсан япон улсын боловсролын системийн хөгжил онцлогоос товч авч үзье.

Мэйжи-гийн шинэчлэлт эхэлснээс хойш засгийн газраас баруун европын эрдэм соёлыг нэвтрүүлэх бодлогыг тууштай баримталж соёл боловсролыг хөгжүүлэхийн тулд бага сургуулиас их сургуулийг хүртэлх боловсролын системийг бий болгож хэрэгжүүлсэн юм. Тухайлбал: 1872 оноос «тосгонд суралцагч үгүй айл өрх байж болохгүй, айл гэрт сургуульд сураагүй иргэн байж болохгүй» хэмээх уриан дор Японд анх удаа бүх нийтээр суралцах системийг бий болгожээ.

1900 онд 6 наснаас эхлэн 4 жил заавал суралцах бүх нийтийн боловсролын системийг тогтоож тухайн онд суралцвал зохих бүх хүүхдийн 90% нь сургуульд элсчээ. 1907 онд энэ системийг 6 жилийн сургалттай болгож суралцвал зохих бүх хүүхдийн 99%-ийг хамруулжээ.

Олон тооны бага, дунд сургууль, охидын дунд сургууль, бүрэн дунд сургууль, тусгай мэргэжлийн сургууль, дээд сургууль зэргийг шинээр байгуулж, бага сургуулиас бусдад иргэд өөрсдийн хүсэлтээр элсэх болжээ. 1935 он гэхэд дунд сургуулийн элсэлтийн хувь 18,5%, бүрэн дунд, тусгай мэргэжлийн болон дээд сургуулийн элсэлтийн хувь 3% байв.

Засгийн газар ингэж боловсролын системдээ их анхаарал тавьж, боловсон хүчнээ дотооддоо бэлтгэж авах бодлогыг явуулжээ. Япон улсад бүх нийтийн сургалтын системийг тухайн үеийн тэргүүний хөгжилтэй Англиас ч өмнө бий болгожээ. Үүний ачаар маш богино хугацаанд бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгажээ. Тухайн үедээ бичиг үсэгтэй, зохих хэмжээгээр гэгээрсэн ард түмнийхээ хүчийг аж үйлдвэрийг хөгжүүлэх бодлоготой уялдуулан ашиглажээ. Ингэснээр Японы эдийн засаг жигд өндөр хөгжиж чадсан юм. Мэйжигийн Засгийн газар байгуулагдсанаас дэлхийн 2-р дайн эхлэх хүртэл 70 гаруй жилийн хугацаанд эдийн засгийн өсөлт жилд дундажаар 4—5% байсан нь тухайн үеийн Америк, Европын хүчирхэг орнуудын хөгжлөөс ч өндөр байлаа.

Энэ үед засгийн газраас идэвхитэй нээлттэй бодлогын далбаан дор тэргүүний технологи, системийг нэвтрүүлж, ард түмэндээ, ялангуяа залуу үедээ тэрхүү тэргүүний технологи, системийг япон маягаар хүлээн авч, цааш хөгжүүлж чадахуйц боловсрол мэдлэгийг эзэмшүүлжээ. Тариачид үйлдвэрийн ажилчид, худалдаачдыг анги ялгаварлан үзэхийг зогсоож ард түмэнд бүх нийтийн тэгш боловсрол олгожээ.

Японыг орчин үеийн улс болгоход нийт ард түмний мэдлэгийн түвшинг өндөр байлгах шаардлагатай гэдэг үзлийн үүднээс суралцагчдын тоог өсгөж, боловсон хүчин бэлтгэх бодлогыг системтэй хэрэгжүүлжээ. Гэвч харамсалтай нь энэ хөгжил удаан үргэлжилсэнгүй. 1920-иод оны сүүлчээс милитаризм сэргэж, Японы гадаад улс

төрийн байдлыг хурцатган хөрш орнуудын эсрэг түрэмгий дайн өдөөхөд хүргэсэн юм. Гэхдээ Япончуудын унших, бичих дур сонирхол эрдэм боловсрол эзэмших хүсэл эрмэлзлэлийг чухам Мэйжи-гийн шинэчлэлийн үеэс л оргилуулж чадсан бөгөөд энэ хүсэл эрмэлзлэл түүний дараах Тайшө (1911—1924), Шовагийн (1925—1989)-ийн үеийг дамжин одоо ч буураагүй, ард түмнийхээ дунд оршсоор байна.

Дайны дараа 1947 онд Японы ардчилсан шинэ Үндсэн хуулийн үзэл санааны үндсэн дээр боловсролын хуулийг баталсан нь одоо хүртэл мөрдөгдөж байна. Удиртгал болон 11 зүйлээс бүтсэн энэ хуулинд боловсролын зорилгын тухай заахдаа «Боловсрол нь бие хүнийг төлөвшүүлж энх тайванч улсыг бүтээн байгуулагчийнх нь хувьд шударга ёсыг дээдлэн, хөдөлмөр хариуцлагыг ухааран бусдыг хүндэтгэгч, эрх чөлөөт, эрүүл чийрэг ард түмнийг өсгөн төлөвшүүлэх зорилготой» гэжээ. Мөн энэ хуулинд боловсролын чиг хандлага, тэгш байдал, нийтээр эзэмших боловсрол, эрэгтэй эмэгтэй, гарал үүсэл ялгаварлахгүй боловсрол эзэмшүүлэх, улс төрийн болон шашны боловсрол зэргийн тухай заажээ.

Мөн 1947 онд боловсролын хуулийн зэрэгцээ сургуулийн сургалтын хуулийг баталж бага, дунд, бүрэн дунд сургууль, их сургууль тусгай болон асрамжийн хүүхдийн сургууль, цэцэрлэг зэрэг сургалтын байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагааны чиглэлийг хуульчилан тогтоожээ. Дайнаас хойш хэрэгжсэн сургуулийн 6, 3, 3, 4 жилийн сургалтын шаталсан системийг мөн энэ хуулийн дагуу тогтоожээ.

Одоо Японы сургуулийн систем нь бага сургууль 6 жил, дунд сургууль 3 жил, бүрэн дунд сургууль 3 жил, их сургууль 4 жилийн системтэй байна.

— Бага сургуульд 6 настайгаас элсч, нийгмийн дунд өдөр тутмын амьдралд шаардлагатай мэдлэг олгох сургалт явуулдаг. Ялангуяа хүүхдэд төрөлх хэлийг нь сайн эзэмшүүлж, канжи үсэг сургах хичээл түлхүү ордог. Мөн тооны сургалт америк, европын улсуудынхаас ахиу хурдтай явагдаж, ихэвчлэн бүх хичээлийг нэг багш заадаг ажээ.

— Дунд сургууль улс нийгмийг бүтээн байгуулагчийнх нь хувьд шаардлагатай зан чанар, мэдлэгийг эзэмшүүлдэг. Ажил хөдөлмөрийн талаар үндсэн мэдлэг, арга барилтай болгож, ирээдүйн амьдралын замаа сонгож авах чадавхийг эзэмшүүлдэг ажээ. Бага сургуулийг бодвол дунд сургуульд дэг журам сайтай. Сурагчийн дүрэмт хувцсыг өмсөнө. Том хотуудын дунд сургууль дунджаар 6000 гаруй сурагчтай ажээ. Дунд сургуульд англи хэл үзнэ. Нэг мэргэжилтэн багш дунджаар 9 сургуульд англи хэл зааж, нэг сургуульд 7 хоногт 2 удаа ирдэг. Дунд сургуульд хичээл тус бүрийг мэргэжлийн багш нар заана.

Японд нийт сургуулийн хичээлийн жил 4-р сард эхэлж, дараа оны 3-р сард төгсөнө. Дунд сургуулийн төгсөлтийн ёслолд Япон хүн болсныг нь мэдрүүлэх зорилгоор Боловсролын яамны шийдвэрээр төрийн далбааг байрлуулж сүлд дуулал Кимигаёог дуулдаг. Мөн энэ төгсөлт нь Японы нийгмийн дараачийн шатанд орлоо гэсэн утгатайгаар төгсөлтийн үнэмлэхийг нэг бүрчлэн гардуулна. Даширамд тэмдэглэхэд заавал эзэмших боловсролыг эзэмшээд Англид төгсөгчдийн хагас хувь нь ажилд гардаг бол Японд дөнгөж 4 хувь нь ажилд гарч 96 хувь нь цааш суралцдаг байна. Бүх нийтийн боловсрол эзэмшүүлэх дунд сургуулийн зорилго нь зөвхөн дээд сургуульд сайн оюутан бэлтгэхэд зориулагдахгүй харин Японы аж үйлдвэрийн нийгэмд зохих төвшинг хангасан ажиллах хүчин бэлтгэхэд чиглэгдэх ёстой ажээ.

Бага дунд сургуулийг нийлүүлсэн дээрх 9 жилийн сургалт нь бүх нийтээр заавал эзэмших боловсрол юм. Японы Үндсэн хуулийн 26-р зүйлд эцэг эх нь үр хүүхдээ сургуульд сургах үүрэгтэйг заажээ. Мөн хот тосгод нь сургууль байгуулах үүрэг хүлээдэг.

— Бүрэн дунд сургуульд дунд сургууль төгсөгчдийг элсэлтийн шалгалтын үндсэн дээр элсүүлдэг. Улс нийгмийг бүтээн байгуулагчийнх нь хувьд зохих зан чанарыг төлөвшүүлж, нийгмийн гишүүний үүргээ ухамсарлахад нь тусалж, хувийн чанарыг нь харгалзан ирээдүйгээ сонгоход нь хэрэгтэй ерөнхий боловсролын болон мэргэжлийн дадлага эзэмшүүлэх хичээлийг заадаг. Мэргэжлийн дадлага эзэмшүүлэх хичээл нь аж үйлдвэр, газар тариалан, худалдаа, усны аж ахуйн гэх мэт дотроо олон салбартай. Аж үйлдвэрийн салбарын хичээл гэхэд л машин техник, цахилгаан эрчим хүч, хими, барилга, төмөрлөг гэх мэтээр хуваагдана. Бүрэн дунд сургууль нь ихэвчилэн муж, хот, тосгодын сургуулиуд байхаас гадна хувийн сургууль ч бас бий.

— Их сургуульд бүрэн дунд сургууль төгсөгчдөөс элсэлтийн шалгалт авч элсүүлдэг. Их сургууль эрдэм шинжилгээний гол байгууллагын хувьд оюутанд гүнзгий мэдлэг эзэмшүүлэхийн зэрэгцээ нарийн судалгааны ажлыг явуулж оюуны, зан суртахууны мөн ажил хэргийн чадавхийг хөгжүүлнэ. Өөрөөр хэлбэл их сургууль нь боловсролын байгууллагын зэрэгцээ эрдэм шинжилгээ судалгааны байгууллагын хувьд ихээхэн үүрэгтэй. Суралцах хугацаа нь ихэнх сургууль 4 жил, харин анагаах ухаан, шүдний эмнэлгийн сургуулиуд 6 жил байдаг. Аспирантур 2 жил, докторантур 3 жил, анагаах ухаан, шүдний эмнэлгийн их сургуулиуд аспирантургүй, докторантур нь 4 жил суралцдаг. Их сургууль нь улсын ба хувийн сургуулиуд байх бөгөөд тооны хувьд хувийн их сургуулиуд маш олон ажээ.

Эдгээрээс гадна 2 жилийн их сургууль, тусгай мэргэжлийн сургууль (дунд сургууль төгссөний дараа 5 жилийн сургалттай) мөн сургуулийн өмнөх насны хүүхдийн цэцэрлэг бий.

Орчин үед Японд хүнийг ажилд авах гол нөхцөл нь тухайн хүний мэдлэгийн чадавхи болжээ. Ажилд ороход гарал үүсэл, гэр орны байдал, эцэг эхийн хөрөнгө зорийг харгалзан үзэх явдал нэгэнт үгүй болжээ.

Бие хүний мэдлэг чадварыг хэмжих шалгуур нь тухайн хүн ямар сургуульд суралцаж юу эзэмшив гэдгээр хэмжигддэг гэнэ. Ийм болохоор бүх хүн сайн сургуульд дэвшин суралцах хүсэл тэмүүлэлтэй, тэгээд ч элсэлтийн хувь их өндөр ажээ.

Ялангуяа сүүлийн жилүүдэд их сургуульд элсэх хувь өндөр болсон нь их сургуульд хүүхдээ сургах айл өрхийн орлогын боломж дээшилсэнтэй ч холбоотой ажээ. Японд хэрэг дээрээ ихэнх хүн их сургуульд элсч байгаа учир их сургуулиуд оюутны хоорондын ялгаа их, өөрөөр хэлбэл зөвхөн их сургууль төгссөн гэдгээр мэдлэг боловсролыг тооцохгүй, харин ямар сургууль төгсөв гэдгийг чухалчилдаг ажээ. Эртнээс уламжлалтай сургуулиуд нь судалгааны ажлын түвшингээрээ дэлхийн хэмжээнд дээгүүрт орж, суралцах өрсөлдөөн ч маш их болжээ. Япон улсын боловсролын тухай товчхон дурдахад ийм байна.

Улс орныг хөгжүүлэхэд бодитой нөлөөлж болох хүчин зүйлүүд нь тухайн орны нөхцөл байдалтай уялдан янз бүр байж болох боловч хаанахын ямар ч оронд нийтлэг байж болох нэг зүйл нь ард түмний боловсрол мэдлэг болов уу. Тийм болохоор дэлхийд хөгжлөөрөө тэргүүлж яваа орнуудын боловсролын систем, түүний туулсан замнал

нь тухайн орны нөхцөл байдалтай уялдан янз бүр байж болох боловч засагт шилжин орж байгаа манай орны хувьд улс орны ирээдүй, дэлхий нийтийн хандлагыг урьдчилан зөв харж, түүнд зохицон амьдарч ажиллаж чадах чадвар бүхий үндэсний боловсон хүчин бэлтгэх, цаашлаад ард түмнээ жигд өндөр мэдлэг боловсролтой байлгах зэрэгт хөгжингүй орон Японы боловсролын замналаас үлгэр авах зүйл олон байгаа нь дамжиггүй.

Ул суурьтай, гүнзгий судалгаа хийж амжаагүй болохоор Японы боловсролын системийн олон чухал зүйлсийг энд орхигдуулсан нь мэдээж хэрэг. Гэвч хүн амын ихэнх хувийг хүүхэд залуучууд эзэлдэг, тэднийг сургаж боловсруулах, ирээдүйд Монгол орноо улсын дайтай, авч явах бие хүнийг төлөвшүүлэх тухай багагүй асуудал тулгараад байгаа манай орны нөхцөлд Японы болон бусад тэргүүний орны боловсролын байдлыг цаг хугацаа алдалгүй судалж хэрэгтэй туршлагыг өөртөө ашигтайгаар шингээн ашиглавал ихээхэн ач холбогдол өгнө гэдэгт найдаж байна.

### НОМ ЗҮЙ

1. Нихон (Япон улс) Токио. 1989.
2. Ronald P. Dore. The diploma disease Токио, 1978
3. Сүзүки Шёозоо «Гэндай сангио шякай то киоикү» (Орчин үеийн аж үйлдвэржсэн нийгэм ба боловсрол) Токио, 1991.
4. Нихон Кэйзай Зүсэцү («Японы эдийн засгийн тухай график, тайлбар») Токио, 1989.
5. Зах зээлийн эдийн засаг. Проф. Хироногийн цуврал лекцүүд. УБ., 1990.
6. Нихон Кэйзай Хакушё Хэйсей 3 нэнбан Японы эдийн засгийн цагаан ном Хэйсей 3 оны хэвлэл, Токио, 1991.
7. Гэнда ёого-но кисо Чишики 1992 (Орчин цагийн нэр томъёоны үндсэн мэдлэг) 1992.